



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Түр ажлын байр нь ажил хөдөлмөр эрхэлдэг хүний тоог хий өсгөж, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг бууруулж байна.

АУДИТЫН КОД: СЭА-2022/02-ШТА-ГА

Сүхбаатар сум 2022 он

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Утас: 70362442 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn:

Аудитор З.Золбоо

Утас: 70362442 Цахим хаяг: zolbooz@audit.gov.mn

Аудитор Т.Одсүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



Аудитыг гүйцэтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
Ц.Отгонбаяр

Аудитор
Т.Одсүрэн
З.Золбоо

Хаяг: Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд

2022 оны 05 дугаар сар

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
Аудит зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүйн талаарх мэдэгдэл	4
Үндсэн мэдээлэл	5
БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН ОРОН НУТГИЙН ОНЦЛОГТ ТОХИРСОН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛААГҮЙ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХАНГАГДААГҮЙ БАЙНА.	6
1.1 “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын бичиг баримттай уялдуулсан аймгийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.	7
1.2 Аудитад хамрагдсан 6 жилийн хугацаанд ХЭДС-д аймгийн төсвөөс 269,094.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх нөөц боломжийг төлөвлөөгүй байна.	8
1.3 Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь төрийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.	12
БҮЛЭГ 2. ТҮР АЖЛЫН БАЙР НЬ АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮНИЙ ТООГ ХИЙ ӨСГӨЖ, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА.	13
2.1 Нийтлэг үйлчилгээний төрөл нь зорилтод бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх хүсэл санаачилга, мэдлэгийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй байх зэрэг давуу талтай байна.	13
2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд зорилтод бүлэгт олгож буй бага хэмжээний санхүүгийн дэмжлэг нь ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэхээсээ илүү халамжийн шинж чанарыг агуулж байна.	16
2.3 2016-2021 онуудад ХЭДС-д 391,176.2 мянган төгрөг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.	19
2.4 2016-2021 онуудад мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад олгосон санхүүжилтийн үр дүнд нийт 2697 мэргэжилтэй ажилчид бэлтгэгдсэн байна.	22
2.5 Цар тахлын үед хэрэгжсэн хөтөлбөрүүдийн үр дүнд шинээр нэмэгдсэн ажлын байрны 60.3 хувийг түр ажлын байр эзэлж байна.	23
АУДИТЫГ ДҮГНЭЛТ	25
ЗӨВЛӨМЖ	26
САНАЛ	28
ХАВСРАЛТ	29

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	<i>Аж ахуйн нэгж байгууллага</i>
АДБОУБ	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага</i>
АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
АМЧБ	<i>Ажил мэргэжлийн чиг баримжаа</i>
ЕБС	<i>Ерөнхий боловсролын сургууль</i>
ЗГ	<i>Засгийн газар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын Тамгын газар</i>
ИТХ	<i>иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</i>
МСҮТ	<i>Мэргэжил сургалт үйлдвэрийн төв</i>
МУЕА	<i>Монгол улсын ерөнхий аудитор</i>
МХГ	<i>Мэргэжлийн хяналтын газар</i>
НҮБ	<i>Нэгдсэн үндэсний байгууллага</i>
УИХ	<i>Улсын Их Хурал</i>
ХБИ	<i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</i>
ХХК	<i>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</i>
ХХҮГ	<i>Хөдөлмөр халамж үйлчилгээний газар</i>
ХЭДС	<i>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан</i>
ШШГГ	<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар</i>

Хүснэгтийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт-1	<i>ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүжилтийн төсвийн төслийн санал</i>	10
Хүснэгт-2	<i>ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт</i>	11
Хүснэгт-3	<i>Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүн</i>	13
Хүснэгт-4	<i>Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо</i>	15
Хүснэгт-5	<i>Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл</i>	16
Хүснэгт-6	<i>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт</i>	18
Хүснэгт-7	<i>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай шийдвэрүүд</i>	19
Хүснэгт-8	<i>ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	20
Хүснэгт-9	<i>ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн тооцоолол</i>	21
Хүснэгт-10	<i>ХЭДС-ийн зардлын 2016-2021 оны төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	22
Хүснэгт-11	<i>Санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтрэлт</i>	23
Хүснэгт-12	<i>Хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	25
Хүснэгт-13	<i>Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтүүд</i>	25

Дүрслэлийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл-1	<i>ХЭДС-д төвлөрүүлэх орон нутгийн төсвийн орлогын харьцуулалт</i>	12
Дүрслэл-2	<i>Бүлгийн сургалтад хамрагдсан иргэд</i>	16
Дүрслэл-3	<i>Ажилгүйдлийн түвшин</i>	19

Хавсралтын товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт-1	<i>ХЭДС-ийн 2016-2021 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл</i>	

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	<p>Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэв.</p> <p>Дээрх зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">✓ Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх;✓ Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна уу?
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад аймгийн Засаг дарга, ЗДТГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөл, ХХҮГ-ын 2016-2021 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн үйл ажиллагааг /сүүлийн 6 жил/ хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	<p>Аудитад дараах хууль эрх зүйн актыг гол шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:</p> <p>Хууль:</p> <ul style="list-style-type: none">• Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7 дахь заалт;• Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 3-20 дугаар зүйл;• Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 3-6, 8-21, 24 дүгээр зүйл;• Төсвийн тухай хууль;• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4-26 дугаар зүйл;• Монгол Улсын 2017-2021 оны төсвийн тухай хууль;• Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;• Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;• Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;• Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; <p>Улсын Их Хурлын тогтоол:</p>

	<ul style="list-style-type: none"> • 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”; • 2016 оны 320 дугаар тогтоол “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”; • 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; • 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг; • 2001 оны 57 дугаар тогтоол “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”; • 2020 оны 24 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; <p>Засгийн газрын тогтоол:</p> <ul style="list-style-type: none"> • 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”; • 2011 оны 375 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”; • 2016 оны 276 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”; • 2021 оны 42 дугаар тогтоол “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”; • 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”; • 2016 оны 121 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”; • УИХ-ын тогтоол болон Засгийн газрын тогтоолоор баталсан төрөөс баримтлах салбарын бодлого, үндэсний хөтөлбөр, бусад эрх зүйн актууд гэх мэт.
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор З.Золбоо, Т.Одсүрэн нар 2022 оны 03 дугаар сарын 15-аас 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хооронд гүйцэтгэв.</p>
<p>Ерөнхий мэдээлэл:</p>	<p>Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны 29359 өрхөд 108370 иргэн амьдарч байна. Үүнээс 49.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны хүн ам 74971, үүнээс 25537 буюу 34.0 хувь нь ажиллагсад байна.</p> <p>Сэлэнгэ аймгийн ажилгүйдлийн түвшин 2016-2019 онд 5.3-4.7 хувь болж буурч байсан боловч 2020-2021 онд Ковид 19 цар тахлын улмаас 2019 оны суурь түвшингөөс 5 хувиар өссөн байна.</p> <p>ХЭДС-д 2016-2021 онуудад нийт 5,641,534.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 4,423,582.5 мянган төгрөгийг зарцуулан, 4075 иргэдийг хамруулж, шинээр байнгын 1581, түр 3380 ажлын байр бий болгосон байна.</p>

БҮЛЭГ

1

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх ?

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой уялдуулан орон нутгийн онцлогт тохирсон бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын уялдаа хангагдаагүй байна.

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдаатай байна уу?

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын бичиг баримттай уялдуулсан аймгийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

1.1.1 Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан байна. Энэ нь “Хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулах” зорилготой. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах 5 үндсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийг хөгжлийн бодлогын үндэс болгох замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшнийг бууруулах,
2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх,
3. Иргэний мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх замаар боловсролын түвшнээс хамааралтай ажилгүйдлийг бууруулах,
4. Ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг дээшлүүлэх,
5. Хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх гэх мэт.

1.1.2 Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ гэж тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн хүмүүжил, ажил, мэргэжлийн зөв хандлага төлөвшиж, эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөр эрхлэлтийн харилцан хамаарал сайжирсан байна;

- ✓ *Ажил олгогчийг дэмжих механизм боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшин, ногоон ажлын байр нэмэгдсэн байна;*
- ✓ *Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү багасаж, ажилгүйдлийн түвшин буурсан байна;*

1.1.3 ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2-т “Хөдөлмөр дэмжих тухай хууль төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тухай орон нутагт зохион байгуулах, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн аймгийн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар санал боловсруулж ИТХ, холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх” гэж заасан байдаг.

1.1.4 Гэвч аймгийн хэмжээнд орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан батлуулалгүйгээр зөвхөн ЗГ-ын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зорилтуудыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоо”-той хөгжлийн бодлогын хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.1.5 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны чиглэл”-д дараах 7 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- *Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгыг үндэслэн, мэргэжилтэй ажилтан бэлтгэж, байнгын ажлын байрыг бий болгоно,*
- *Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, цахим мэдээллийн санг өргөжүүлэх, иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, ажилгүй иргэдийг ажилд зуучилна,*
- *Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар 4000-аас доошгүй шинэ ажлын байр бий болгоно,*
- *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ,*
- *Айл өрх бүрээс 1-ээс доошгүй хүн, мөн 40-өөс дээш насны иргэн ажилтай байх, хөдөлмөр эрхлэлтийн шинэ бодлогыг хэрэгжүүлнэ,*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна,*
- *Харьцангуй бага орлоготой айл өрхийг туслах аж ахуй эрхлүүлэх замаар ажлын байр, амьжиргааны эх үүсвэртэй болгох.*

1.1.6 Эдгээр зорилтууд нь ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудтай нийцсэн боловч төсөв санхүү, түүний эх үүсвэр, хүрэх түвшин, хэрэгжих хугацааны хувьд харилцан уялдаагүй, нэгдсэн судалгаа, шинжилгээнд үндэслээгүй байна.

1.1.7 Сэлэнгэ аймгийн ЗДТГ болон Европын холбооны санхүүжилттэй Монгол улсад ажлын байр нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх “SECIM” төслийн эх үүсвэрээр

анх удаа аймгийн хэмжээний “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа” хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2018 оны А/198 дугаар захирамжаар байгуулан, хөдөлмөр эрхлэлтийн дунд хугацааны стратеги боловсруулах ажлыг эхлүүлсэн байна.

1.1.8 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тооцоолохдоо Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.1-т “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн урт болон богино хугацааны төлөв байдлыг судлах, хэтийн тооцоо боловсруулах”, 30 дугаар зүйлийн 30.1.14-т “Хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг тодорхой давтамжтайгаар хийх, мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах” гэсэн заалтыг үндэслэл болгосон байна.

1.1.9 “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны үр дүнд хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, эрэлттэй болон илүүдэлтэй ажил мэргэжлийг тодорхойлох, хүүхэд залуучуудын мэргэжил сонголтод нөлөөлөх зэрэг чиглэлээр мэдээллийн дэлгэрэнгүй сантай болсон боловч уг судалгааг үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтэд ашиглаагүй байна.

1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Аудитад хамрагдсан 6 жилийн хугацаанд ХЭДС-д аймгийн төсвөөс 269,094.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх нөөц боломжийг төлөвлөөгүй байна.

1.2.1 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны чиглэл”-ээр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгайлан төлөвлөж, батлаагүй байна.

1.2.2 Харин ХЭДС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.1-д “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилд орон нутагтаа хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, тэдгээрт сан болон дэд сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг **аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ.**” гэж заасны дагуу төлөвлөн, хүргүүлж байна.

1.2.3 Хэдийгээр ХЭДС-ийн хөрөнгийг аймгийн ХХҮГ-аас төлөвлөн, холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлж байгаа боловч дээрх заалтын дагуу төсвийн төслийг аймгийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөл”-өөр хэлэлцэн, баталгаажуулаагүй байна.

1.2.4 ХЭДС-ийн эх үүсвэрийг аудитад хамрагдсан 2016-2021 онуудад өмнөх жилүүдийн төлөвлөлт, гүйцэтгэлд үндэслэн 974,800.0 - 1,476,858.0 мянган төгрөгөөр тооцож, төсвийн төсөлд тусган хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт1. ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн төсөл /мянган төгрөг /

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих	15,000.0	17,400.0	9,450.0	15,000.0	18,000.0	18,000.0
2	Ажилд зуучлах үйлчилгээ	5,000.0	5,000.0	11,060.0	7,000.0	12,600.0	12,600.0
3	Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байр хадгалах	109,800.0	77,398.0	79,665.0	39,200.0	42,460.0	21,110.0
4	Ажлын байрыг дэмжих	330,680.0	358,380.0	545,270.0	369,200.0	668,260.0	527,540.0
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	-	55,220.0	47,250.0	54,920.0	211,540.0	136,540.0
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	71,200.0	76,916.0	141,190.0	103,360.0	143,100.0	108,020.0
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	351,120.0	229,700.0	315,000.0	181,250.0	238,250.0	232,788.0
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	45,000.0	18,000.0	44,600.0	27,880.0	70,200.0	42,480.0
10	Сургалт болон бусад арга хэмжээний зардал	47,000.0	63,360.0	65,950.0	63,848.0	72,448.0	97,358.0
	Нийт дүн	974,800.0	901,374.0	1,259,435.0	861,658.0	1,476,858.0	1,196,436.0

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2022 оны төсвийн төсөөллийн тайлан

1.2.5 Хүснэгтээс харахад хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байр хадгалах, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийн төлөвлөлт жил ирэх бүр буурах хандлагатай байгаа бол бусад хөтөлбөрүүдийнх нэмэгдэх хандлагатай байна. Үүнээс ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эх үүсвэрийн төлөвлөлт 2016 онд нийт санхүүжилтийн 33.9 хувийг эзэлж байсан бол 2021 онд 44,1 хувийг эзлэх болж 59,5 хувиар нэмэгдсэн байна.

1.2.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлд¹ ХЭДС- нь 9 эх үүсвэрээс санхүүжихээр зааж өгсөн бөгөөд эдгээрээс дараах 5 эх үүсвэр нь аймгийн ХЭДС-д хамаарахаар байна. Үүнд:

¹ 22.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: 22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө; 22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө; 22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдээдлийг банкинд хадгалуулсны хүү; 22.1.4.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгоогчийн төлөх ажлын байрны төлбөр; 22.1.5.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл; 22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж; 22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

- Улсын төсвөөс хуваарилах хөрөнгө,
- Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгө,
- Гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр,
- Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө гэх мэт.

1.2.7 Аудитад хамрагдсан онуудын ХЭДС-ийн эх үүсвэр буюу санхүүжилтийн төсвийн төсөл, гүйцэтгэлийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Хүснэгт 2. ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн төсөл, гүйцэтгэл /мянган төгрөг/

Он	Үзүүлэлт	Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө	Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө	ХБИ ажиллуул-аагүйн төлбөрийн орлого	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж	Нийт дүн
2016	Төсвийн төслөөр	974,800.0			-	-	974,800.0
	Гүйцэтгэлээр	573,000.0		8,985.6	76,825.6	-	658,811.2
	Зөрүү	(401,800.0)	-	8,985.6	76,825.6	-	(315,988.8)
2017	Төсвийн төслөөр	901,374.0		10,000.0			911,374.0
	Гүйцэтгэлээр	918,800.0		14,328.0	166,388.4		1,099,516.4
	Зөрүү	17,426.0	-	4,328.0	166,388.4	-	188,142.4
2018	Төсвийн төслөөр	1,249,435.0		10,000.0			1,259,435.0
	Гүйцэтгэлээр	973,500.0		1,728.0	289,576.7		1,264,804.7
	Зөрүү	(275,935.0)	-	(8,272.0)	289,576.7	-	5,369.7
2019	Төсвийн төслөөр	861,658.0					861,658.0
	Гүйцэтгэлээр	1,143,000.0		86,345.3	489,672.6		1,719,017.9
	Зөрүү	281,342.0	-	86,345.3	489,672.6	-	857,359.9
2020	Төсвийн төслөөр	1,476,858.0		10,000.0	366,226.6		1,853,084.6
	Гүйцэтгэлээр	602,000.0		161,912.7	509,808.8	18,682.0	1,292,403.5
	Зөрүү	(874,858.0)	-	151,912.7	143,582.2	18,682.0	(560,681.1)
2021	Төсвийн төслөөр	1,191,732.0		10,000.0	393,567.4		1,595,299.4
	Гүйцэтгэлээр	626,126.0		35,172.0	451,461.4	1,748.9	1,114,508.3
	Зөрүү	(565,606.0)	-	25,172.0	57,894.0	1,748.9	(480,791.1)
НИЙТ ДҮН	Төсвийн төслөөр	6,655,857.0	-	40,000.0	759,794.0	-	7,455,651.0
	Гүйцэтгэлээр	4,836,426.0	-	308,471.6	1,983,733.5	20,430.9	7,149,062.0
	Зөрүү	(1,819,431.0)	-	268,471.6	1,223,939.5	20,430.9	(306,589.0)

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

1.2.8 Хүснэгтээс харахад ХЭДС-ийн эх үүсвэрийг төлөвлөх үйл ажиллагаа нь дараах байдалтай байна. Үүнд:


- Аймгийн төсвөөс тухайн жилийн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүйгээр тооцож, хөрөнгө төвлөрүүлэхээр зохицуулагдсан атал огт төлөвлөөгүй,

22.1.8. жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө; 22.1.9. бусад эх үүсвэр.

- Гадаад тусламжаас сүүлийн 2 жилд тодорхой хэмжээний эх үүсвэр бүрдүүлж байгаа боловч нөөц боломжийг бүрэн ашиглахаар төлөвлөөгүй,
- ХБИ ажиллуулаагүй ААНБ-аас төлөх төлбөрийн орлогыг 25-аас дээш ажилтантай ААН-ийн судалгаа болон хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутам сар бүр төлөх төлбөрийг хэмжээг үндэслэн тооцохоор зохицуулагдсан байна. Гэтэл 2016, 2019 онд төлөвлөөгүй, бусад онуудад тус бүр 10,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн буюу аудитад хамрагдсан 6 жилд нийт 40,000.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 308,471.6 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд нөөц боломжийг бүрэн ашиглахаар төлөвлөөгүй,
- Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 2017 оноос эхлэн орлогын эх үүсвэрээр тооцож, эргэн төлөлтийн авлагыг он, оны насжилтаар гарган төлөвлөхөөр зохицуулагдсан атал 2017-2019 онуудад огт төлөвлөөгүй, 2020-2021 онуудад нөөц боломжийг тооцож, бүрэн төлөвлөөгүй,
- Улсын төсвөөс олгох санхүүжилтийг өмнөх жилийн гүйцэтгэл болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах хүний тоог үндэслэн бодитоор төсвийн төсөл боловсруулж, хуваарилаагүйгээс хүргүүлсэн төсвийн төсөл, олгосон санхүүжилтийн зөрүү 2016, 2018, 2020, 2021 онуудад эрс ялгаатай, ялангуяа 2020-2021 онд 90,3 хувиас 1.4 дахин зөрүүтэй байна.

1.2.9 ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна” гэж заасны дагуу орон нутгийн төсвөөс төвлөрүүлэхээр төлөвлөх боломжит орлогыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1. ХЭДС-д орон нутгийн төсвөөс төвлөрүүлэхээр төлөвлөх боломжит орлого /мянган төгрөг/



Эх сурвалж: Дүн шинжилгээ

1.2.10 Дүрслэлээс харахад тус санд орон нутгийн төсвөөс 2016-2021 онуудад тус бүр 43,754.4 - 54,185.7 мянган төгрөг буюу нийт 269,094.9 мянган төгрөгийн орлого төлөвлөж, төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна уу?

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь төрийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

1.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дах заалтаар “Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийг байгуулж, ажиллуулах”-аар зохицуулсан бөгөөд ЗГ-ын 2011 оны 350 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг баталж, 2020 оны 147 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан байна.

1.3.2 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг нийслэлийн зөвлөлийн дүрэм”-д тодорхойлсноор тус зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах үндсэн үүрэгтэй байна.

1.3.3 Дээрх дүрмийн 3 дугаар зүйлд зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга байхаар зохицуулагдсан атал аймгийн Засаг даргын 2015 оны А/256 дугаар захирамжаар зөвлөлийн даргаар 2015-2017 оны 4 дүгээр сар хүртэл Засаг даргын орлогчийг томилон ажиллуулж байсан байна.

1.3.4 Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь төр, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчийн тус бүр 3, нийт 9 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдахаар зохицуулагдсан атал төрийн байгууллагуудын төлөөлөл болон нийт бүрэлдэхүүнийг тус бүр 1-2 хүнээр хэтрүүлэн, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөллийг 1 хүнээр дутуу бүрдүүлж байсан байна. Үүнийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Хүснэгт 3. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Аймгийн засаг даргын захирамж		Төрийн төлөөлөл	Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөл	Ажил олгогчийн төлөөлөл	Нийт гишүүдийн тоо
огноо	дугаар				
2015.06.09	А/256	4	3	3	10
2017.04.10	А/160	5	2	3	10
2018.05.17	А/176	5	2	3	10
2021.02.10	А/40	5	3	3	11

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2015-2021 оны захирамжууд

1.3.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн зөвлөл нь дүрэмд заасан 8 эрх, 9 үүрэг нийт 17 үзүүлэлтээс 4-ийг нь хангалтгүй хэрэгжүүлж, 13-ыг нь огт хэрэгжүүлээгүй бөгөөд удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанд нь дараах зөрчил оршиж байна. Үүнд:

- ✓ 2016-2021 онуудад нийт 6 удаа хуралдсан байхад зөвлөлийн дарга буюу аймгийн Засаг дарга зөвхөн 1 удаагийн хуралдаанд оролцсон буюу зөвлөлийг удирдан чиглүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй,
- ✓ Зөвлөл нь хагас жил тутамд нэгээс доошгүй хуралдахаар зохицуулагдсан атал 2020-2021 онуудад тус бүр 1 удаа хуралдаж, 2016, 2018 онуудад огт хуралдаагүй,
- ✓ Зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмж, санал, дүгнэлтийг гишүүдийн гарын үсгээр баталгаажуулаагүй,
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн дүрмийн 3.4-т заасан 3 тал бүрээс 2 гишүүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно гэсэн шалгуурыг хангаагүй байхад 2019 онд хурлын ирцийг хүчинтэйд тооцож хуралдааныг зохион байгуулсан гэх мэт.

1.3.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн зөвлөлийн хурлаар аймгийн ХХҮГ-ын 2019 оны хагас, бүтэн жил, 2021 оны жилийн эцсийн ажлын тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргасан бөгөөд ХЭДС-ийн 2017, 2019, 2020 онуудын батлагдсан төсвийг нийт сумдын иргэдэд жигд, хүртээмжтэй, ил тод захиран зарцуулахтай холбоотой 3 зөвлөмж, 2017 онд зорилтод төслийг хэлэлцэн 3 саналыг ХХҮГ-т хүргүүлснээс бусдаар хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

1.3.7 Иймээс холбогдох төрийн байгууллагууд дээд шатны байгууллагуудаас өгсөн чиглэлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн бөгөөд өөр хоорондын ажлын уялдаа, холбоо хангалтгүй байна.

1.3.8 Өөрөөр хэлбэл аймгийн ХХҮГ нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, үүний үр дүнг үндэслэн аймгийн Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт болон бусад хөтөлбөр, бодлогын баримт бичгүүд, төлөвлөгөөний гүйцэтгэлийг тооцсон байна.

БҮЛЭГ 2

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна уу?

Түр ажлын байр нь ажил хөдөлмөр эрхэлдэг хүний тоог хий өсгөж, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг бууруулж байна.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?

Нийтлэг үйлчилгээний төрөл нь зорилтод бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх хүсэл санаачилга, мэдлэгийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй байх зэрэг давуу талтай байна.

2.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана” гэж, 6 дугаар зүйлийн 6.2-т хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах,
- Ажилд зуучлах,
- Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах.

2.1.2 Аймгийн ХХҮГ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онуудад нийт 15617 иргэнийг хамруулсан байна.

2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2016 оноос 2019 он хүртэл байнга өсөн нэмэгдэж байсан бөгөөд 2020-2021 онд Ковид 19 цар тахлаас шалтгаалан огцом буурсан байна.

Хүснэгт 4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт дүн
Ганцаарчилсан зөвлөгөөгөө өгөх, АМЧБО	672	450	788	826	571	468	3775
Бүлгийн зөвлөгөө өгөх, АМЧБО	486	933	1295	2017	556	104	5391
Ажилд зуучлах	1100	966	1032	1199	1053	1101	6451
Нийт дүн	2258	2349	3115	4042	2180	1673	15617


Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны үйл ажиллагааны тайлан

2.1.4 Аудитад хамрагдсан хугацаанд буюу 2016-2021 онуудад ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд дараах байдлаар хамруулсан байна. Үүнд:

- Мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, мэргэжил гэх мэт ажил, мэргэжлийн чиглэлийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд 771 иргэн буюу 20,4 хувь нь,
- Мэргэжил сонголт, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрт бэлтгэх, карьер, сонирхол, ур чадварын чиглэлээр гэх мэт АМЧБ олгох чиглэлийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд 3004 иргэн буюу 79.6 хувь нь.

2.1.5 Бүлгийн сургалтын 70.3 хувийг ЕБС-ийн сурагч, 9.5 хувийг их, дээд сургууль, коллеж, МСҮТ төгсөгч, 2.7 хувийг ажил хайгч, 1.9 хувийг ажил олоход хүндрэлтэй иргэд, 1.4 хувийг ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн зэрэг зорилтод бүлэгт чиглүүлсэн бол 14.2 хувийг ажил эрхэлж буй ажилтан албан хаагч болон бусад ангиллын зорилтод бус бүлэгт чиглүүлсэн байгаа нь хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг бууруулж байна.

Дүрслэл 2. Бүлгийн сургалтад хамрагдсан иргэд / хувиар /



Эх сурвалж: ХЭДС-ийн үйл ажиллагааны тайлан

2.1.6 Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээллээр 2016-2021 онд АМЧБ олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 9166 иргэн хамрагдсан бөгөөд үүний үр дүнд 969 иргэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл хөтөлбөрт хамрагдаж ажлын байртай болсон, 520 иргэн мэргэжил эзэмшсэн, 1223 иргэн байнгын болон түр ажлын байранд зуучлагдаж, ажлын байраа тогтвортой хадгалж ажилласан байна.

2.1.7 Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2016-2021 оны хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд ААНБ-аас нийт 7620 ажлын байрны захиалга, шинээр 13251 иргэн ажил хайгчаар бүртгүүлснээс 7791 иргэн ажил хайх идэвхгүйн улмаас хасагдаж, 6451 иргэн ажилд зуучлагдсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл / тоогоор /

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт дүн
Оны эхний ажилгүй	798	858	824	745	639	661	
Тайлант онд шинээр ажил хайгчаар бүртгүүлсэн	1692	2284	2718	2784	1638	2135	13251
Идэвхгүйн улмаас хасагдсан	1390	1352	1765	1691	563	1030	7791
Ажилд зуучлагдсан	1100	966	1032	1199	1053	1101	6451
Оны эцсийн ажилгүй	858	824	745	639	661	665	
Захиалсан ажлын байр	1297	1077	1197	1379	1085	1585	7620

Эх сурвалж: ХЭДС-ийн үйл ажиллагааны тайлан

2.1.8 Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд нэгдсэн бүртгэл мэдээллийн үйлчилгээний дараах программуудыг ашиглаж байна. Үүнд:

- 2013 оноос эхлэн нэвтрүүлсэн, ажил олгогч, хайгч, ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, шинэ ажлын байр, ажил мэргэжлийн чиг баримжаа авсан иргэдийн мэдээ тайланг гаргах хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн www.lmis.gov.mn программ,
- 2015 оноос эхлэн нэвтрүүлсэн, санхүүгийн дэмжлэгийг бүртгэх www.hedsexplorer.net онлайн программ.

2.1.9 Imis.gov.mn программд 2016-2018 онуудад зөвхөн шинээр бий болсон байнгын ажлын байр бүртгэгддэг байсан бол 2019 оноос улирлын болон түр ажлын байрыг бүртгэж байна.

2.1.10 Аудитын явцад хөдөлмөрийн зах зээлд оролцогчид болох шинээр ажлын байр бий болгосон ААНБ, иргэдийн бүртгэлийг түүврээр шалгаж үзэхэд 2016 онд 45, 2018 онд 100 улирлын ажлын байрыг байнгын ажлын байраар бүртгэсэн байна.

2.1.11 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2²-т ажил олгогч нь сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам харьяа хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад гаргаж өгөхөөр заасан байна.

2.1.12 Гэвч зарим ажил олгогч байгууллагууд сул ажлын байрны мэдээллээ гаргаж өгдөггүй буюу ажилтан хайгаад олдохгүй нөхцөлд аймгийн ХХҮГ-т хандаж зуучлуулах хүсэлт өгч байгаа нь нэг талаар төр, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоо муу, хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, сурталчилгаа хангалтгүйгээс шалтгаалж байгаа бол нөгөө талаар аймгийн хөдөлмөрийн зах зээлийн хөдлөл, өөрчлөлт болон сул ажлын байрны мэдээлэл бодитоор гарахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.1.13 Аудитын дүнгээс харахад нийтлэг үйлчилгээний төрөл буюу ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах зэрэг үйл ажиллагаа нь нэг талаас зорилтод бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх хүсэл санаачилга, мэдлэгийг нэмэгдүүлэх, нөгөө талаас ХЭДС-ийн хөрөнгийг хэмнэх, хүртээмжтэй байх зэрэг давуу талтай байна.

2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна уу?

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд зорилтод бүлэгт олгож буй бага хэмжээний санхүүгийн дэмжлэг нь ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэхээсээ илүү халамжийн шинж чанарыг агуулж байна.

2.2.1 ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээг ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, залуучууд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, ажил олгогч зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын зорилтот бүлгүүдэд чиглүүлэн хэрэгжүүлж байна.

² Ажил олгогч нь ажиллах хүч болон ажлын байрны холбогдолтой мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид гарган өгөх, эсхүл түүний бүртгэл, мэдээллийн сүлжээнд бүртгүүлж, мэдээллээ байршуулах, мэдээлэлд оруулж байгаа өөрчлөлтийг тухай бүрд нь хийж байх үүрэгтэй бөгөөд ажил олгогч нь нийт ажлын байрныхаа талаарх мэдээллийг оны эхэнд нэг удаа, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр нь энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, хөдөлмөрийн биржид гаргаж өгнө.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

2.2.2 Аудитад хамрагдсан хугацаанд буюу 2016-2021 онуудад ХЭДС-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд нийт 4075 хүнийг хамруулан, дараах хөтөлбөрүүдээр дамжуулан нийт 3,503,604.1 мянган төгрөгийг зарцуулж, зорилтот бүлгийн нийт 4403 ажлын байр /байнгын 1581, түр 2822/ -ыг бий болгосон байна.

Хүснэгт 6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт

Он	Үзүүлэлт	Байнгын ажлын байр					Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт	Байнгын ажлын байрны нийт тоо	Түр ажлын байрны тоо
		ХБИ дэмжих хөтөлбөр	ЗХЭД, гарааны бизнесийг дэмжих	Малчдын хөдөлмөр эрхлэлт	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ			
2016	Хүний тоо	31	9	45	88		10	183	340
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	31,000.0	18,000.0	197,660.0	121,780.0		7,200.0	375,640.0	100,067.5
	Бий болсон ажлын байр	31	9	90	180		10	320	340
2017	Хүний тоо	21	9	57	81	15	11	194	672
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	49,000.0	18,000.0	173,900.0	233,150.0	37,500.0	6,540.0	518,090.0	193,677.4
	Бий болсон ажлын байр	32	90	114	121	15	10	382	429
2018	Хүний тоо	10	10	60	60	6	27	173	619
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	28,100.0	40,785.0	268,860.0	169,500.0	15,000.0	16,200.0	538,445.0	135,400.0
	Бий болсон ажлын байр	10	5	120	119	6	25	285	629
2019	Хүний тоо	13	18	52	57	19	27	186	711
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	52,000.0	180,000.0	242,600.0	262,000.0	7,392.0	9,936.0	753,928.0	138,904.2
	Бий болсон ажлын байр	13	18	104	107	9	27	278	711
2020	Хүний тоо	15		30	40	8		93	265
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	63,000.0		141,000.0	171,500.0	24,000.0		399,500.0	59,190.0
	Бий болсон ажлын байр	27		60	97	9		193	264
2021	Хүний тоо	20	1	18	36	9		84	555
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	85,600.0	10,000.0	84,000.0	162.0	27,000.0		206,762.0	84,000.0
	Бий болсон ажлын байр	20	1	35	58	9		123	449
Нэгтгэл	Хүний тоо	110	47	262	362	57	75	913	3162
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	308,700.0	266,785.0	1,108,020.0	958,092.0	110,892.0	39,876.0	2,792,365.0	711,239.1
	Бий болсон ажлын байр	133	123	523	682	48	72	1581	2822

Эх сурвалж: ХХҮГ-ын үйл ажиллагааны мэдээ, тайлан.

2.2.3 2016-2021 онуудад нийт 4403 ажлын байр бий болгосны 35.9 хувийг байнгын, 64.1 хувийг түр ажлын байр эзэлж байгаа буюу уг хөтөлбөрийн үр дүнд тогтвортой ажлын байраар бүрэн хангагдаж чадахгүй байна.


2.2.4 Түр ажлын байрыг шинээр бий болгосон ажлын байранд оруулан тооцож байгаагаас ажлын байраар хангасан хүний тоо хий нэмэгдэн, бодит байдал дээр ажилгүйдэл буурахгүй байгаа бөгөөд холбогдох байгууллагууд шинэ ажлын байр нэмэгдүүлэхийн тулд байнгын бус түр ажлын байрыг нэмэгдүүлж байна.

2.2.5 ХЭДС-аас 2016-2021 онд 840 иргэнд 2,853,725.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 29 иргэний эргэн төлөлт хугацаа хэтэрч, 53,194.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

2.2.6 ХЭДС-ийн эх үүсвэрээс санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн төлөлт, үлдэгдлийн талаарх мэдээллүүд нь Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдэхгүй байгаа нь хугацаандаа төлөгдөхгүй байх, найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож байна.

2.2.7 Аймгийн Статистикийн хэлтсийн албан ёсны тоо мэдээллээр 2016-2021 онд ажилгүйдлийн түвшин аймгийн дүнгээр 2016-2019 онд 5.3-4.7 хувь болж буурч байсан боловч 2020-2021 онд 2019 оны суурь түвшингээс 5 хувиар өссөн байна.

Дүрслэл 3. Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсийн 2016-2021 оны жилийн эцсийн “Нийгэм, эдийн засгийн танилцуулга”

2.2.8 Аудитын явцад ажлын байр дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад настны зөвлөх үйлчилгээг дэмжих зэрэг хөтөлбөрт хамрагдсан 261 иргэнээс санал асуулга авч нэгтгэн үзэхэд хөтөлбөрт хамрагдахаас өмнө нийт 186 /давхардсан тоогоор/ ажлын байртай байсан бол дэмжлэгт хамрагдсаны дараа 439 ажлын байртай болсон гэж хариулсан байна.

2.2.9 Өөрөөр хэлбэл эдгээр иргэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсаны үр дүнд 186 ажлын байрыг хадгалж үлдэн, 253 ажлын байрыг шинээр бий болгосон байна.

2.2.10 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр зорилтод бүлэгт бага хэмжээний буюу ихэнх тохиолдолд 3000.0-5000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож байгаа ч энэ нь ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөшүүрэг гэхээсээ илүү ажилгүй, орлогогүй, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт эмзэг бүлэгт чиглэсэн халамжийн шинж чанарыг агуулж байна.

2.2.11 Хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэгүүдийн сонгон шалгаруулалтыг жил бүрийн 4, 9 дүгээр сард зохион байгуулахаар зохицуулагдсан боловч хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тушаал, шийдвэрүүд нь оройтож батлагдаж ирдгээс шалтгаалан хөтөлбөр дутуу хэрэгжих, төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Үүнийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Хүснэгт 7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай шийдвэрүүд

Тушаал, шийдвэрийн нэр	Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр			
	2016 он	/2017-2018/ он	/2019-2020/ он	/2021-2022/ он
Хөтөлбөр	ХЭҮЗ-ийн 2015.12.16-ны өдрийн 9-р тогтоол	ХЭҮЗ-ийн 2017.01.17-ны өдрийн 01 дүгээр тогтоол	ХЭҮЗ-ийн 2019.01.14-ны өдрийн 01 дүгээр тогтоол	ХЭҮЗ-ийн 2021.02.02-ны өдрийн 01 дүгээр тогтоол
Удирдамж	ХНХС-ын 2016.01.18-ны өдрийн А/12 дугаар тушаал	ХНХС-ын 2017.02.16-ны өдрийн А/26 дугаар тушаал	ХНХС-ын 2019.03.05-ны өдрийн А/83 дугаар тушаал	ХНХС-ын 2021.04.14-ны өдрийн А/49 дүгээр тушаал

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын жишиг хэмжээ	ХНХС-ын 2016.01.12-ны өдрийн А/06 дугаар тушаал	ХНХС-ын 2017.01.27-ны өдрийн А/18	ХНХС-ын 2019.03.05-ны өдрийн А/82 дугаар тушаал	ХНХС-ын 2021.06.18-ны өдрийн А/96 дугаар тушаал
---	---	-----------------------------------	---	---

Эх сурвалж: ХЭҮЗ-ийн тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүд

2.2.12 Иймд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд нь тухайн жил хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн холбогдох шийдвэрүүдийг өмнөх оны 12 дугаар сард багтаан гаргаж, орон нутгийн байгууллагуудад хүргэж байх шаардлагатай байна.

2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй зарцуулсан уу?

2016-2021 онуудад ХЭДС-д 391,176.2 мянган төгрөг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

2.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д ХЭДС-ийн орлогын эх үүсвэрийг тодорхойлсон байна.

2.3.2 Аймгийн ХЭДС-ийн орлогын эх үүсвэрт тус хуулийн 22.1.3-22.1.5 дахь заалтаас бусад заалт нь хамаарах бөгөөд 2016-2021 онд нийт 5,733,608.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,149,062.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Он	Үзүүлэлт	Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө	Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж	Нийт дүн
2016	Төлөвлөгөө	542,528.1		10,000.0	-	-	552,528.1
	Гүйцэтгэл	573,000.0		8,985.6	76,825.6	-	658,811.2
	Зөрүү	30,471.9	-	(1,014.4)	76,825.6	-	106,283.1
2017	Төлөвлөгөө	1,370,800.0		-			1,370,800.0
	Гүйцэтгэл	918,800.0		14,328.0	166,388.4		1,099,516.4
	Зөрүү	(452,000.0)	-	14,328.0	166,388.4	-	(271,283.6)
2018	Төлөвлөгөө	1,180,929.2					1,180,929.2
	Гүйцэтгэл	973,500.0		1,728.0	289,576.7		1,264,804.7
	Зөрүү	(207,429.2)	-	1,728.0	289,576.7	-	83,875.5
2019	Төлөвлөгөө	1,302,752.0		2,073.6			1,304,825.6
	Гүйцэтгэл	1,143,000.0		86,345.3	489,672.6		1,719,017.9
	Зөрүү	(159,752.0)	-	84,271.7	489,672.6	-	414,192.3
2020	Төлөвлөгөө	580,773.9		50,000.0		18,682.0	649,455.9
	Гүйцэтгэл	602,000.0		161,912.7	509,808.8	18,682.0	1,292,403.5
	Зөрүү	21,226.1	-	111,912.7	509,808.8	-	642,947.6
2021	Төлөвлөгөө	629,754.2		30,000.0		15,315.0	675,069.2
	Гүйцэтгэл	626,126.0		35,172.0	451,461.4	1,748.9	1,114,508.3
	Зөрүү	(3,628.2)	-	5,172.0	451,461.4	13,566.1	466,571.3
НИЙТ	Төлөвлөгөө	5,607,537.4	-	92,073.6	-	33,997.0	5,733,608.0

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

ДҮН	Гүйцэтгэл	4,836,426.0	-	308,471.6	1,983,733.5	20,430.9	7,149,062.0
	Зөрүү	(771,111.4)	-	216,398.0	1,983,733.5	(13,566.1)	1,415,454.0

Эх сурвалж ХЭДС-ийн 2016-2021 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.3.3 Хүснэгтээс харахад тайлант онуудад аймгийн ХЭДС-д дараах эх үүсвэрүүдээс хөрөнгө төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Улсын төсвөөс 5,607,537.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,836,426.0 мянган төгрөг,
- ХБИ ажиллуулаагүйн төлбөрөөс 92,073.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 308,417.6 мянган төгрөг,
- Эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон санхүүгийн дэмжлэгийг тооцож төлөвлөөгүй бөгөөд гүйцэтгэлээр 1,983,733.5 мянган төгрөг,
- Дэлхийн банкны санхүүжилтээр 2020-2021 онд “Жижиг зээл”-д хамрагдсан иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх зориулалтаар 33,997.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 20,430.9 мянган төгрөг төвлөрүүлсэн гэх мэт.

2.3.4 Харин холбогдох хууль, эрхийн актыг хэрэгжүүлээгүйгээс дараах эх үүсвэрээс ХЭДС-д хөрөнгө төвлөрүүлэх нөөц боломжийг алдсан байна. Үүнд:

- Аймгийн төсвөөс тухайн жилийн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүйгээр тооцож, хөрөнгө төвлөрүүлээгүйгээс 2016-2021 онуудад 269,094.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх, /тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.2.10-д харуулав /
- ХХҮГ-т бүртгэлтэй 25-аас дээш ажилтантай 21 ААНБ-ын судалгаагаар тооцоход ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогын эх үүсвэрээс 2019-2021 онуудад 122,081.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх. / тооцооллыг хүснэгт 11-д харуулав /

Хүснэгт 9 . ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн тооцоолол /мянган төгрөг/

№	Төлбөр төлсөн ААНБ-ын нэр	2019 он			2020 он			2021 он			Нийт дүн				
		Төлбөл зохих	төлсөн	Зөрүү	Хүний тоо	Төлбөл зохих	төлсөн	Зөрүү	Хүний тоо	Төлбөл зохих	төлсөн	Зөрүү			
1	Алтан тариа ХХК	8,640.0	-	(8,640.0)								8,640.0	-	(8,640.0)	
2	Сэ.Гаалийн газар	3,895.2	2,877.1	(1,018.1)								3,895.2	2,877.1	(1,018.1)	
3	Спирт бал бурам ХХК	37,800.0	18,705.3	(19,094.7)	4.0	30,240.0	30,222.5	(17.5)	1.0	7,560.0	1,440.0	(6,120.0)	75,600.0	50,367.8	(25,232.2)
4	Бороо гоулд ХХК	12,960.0	-	(12,960.0)	4.0	25,920.0	25,920.0	-					38,880.0	25,920.0	(12,960.0)
5	ЗХ ХААН Банк	-	-	-					1.0	6,480.0	3,420.0	(3,060.0)	6,480.0	3,420.0	(3,060.0)
6	Шар нарст ХХК	-	-	-									-	-	-
7	Монтай эрдэнэ ХХК	3,024.0	576.0	(2,448.0)	1.0	3,024.0	576.0	(2,448.0)	1.0	3,024.0	1,152.0	(1,872.0)	9,072.0	2,304.0	(6,768.0)
8	Сентеррагоулд Монголиа ХХК	6,480.0	-	(6,480.0)	1.0	6,480.0		(6,480.0)					12,960.0	-	(12,960.0)
9	Сэ.ХААН Банк	6,480.0	864.0	(5,616.0)									6,480.0	864.0	(5,616.0)
10	Болдтөмөр ерөө гол ХХК	96,120.0	60,442.8	(35,677.2)	6.0	38,448.0	90,568.2	52,120.2					134,568.0	151,011.0	16,443.0
11	Майн гач ХХК-Баянгол сум	4,320.0	288.0	(4,032.0)	1.0	4,320.0		(4,320.0)					8,640.0	288.0	(8,352.0)
12	Сэ.Төрийн Банк	19,440.0	2,592.0	(16,848.0)									19,440.0	2,592.0	(16,848.0)
13	Цант орхон ХХК	-	-	-	1.0	3,024.0	1,485.3	(1,538.7)					3,024.0	1,485.3	(1,538.7)
14	Тод ундрага ХХК	-	-	-	1.0	10,800.0	13,140.7	2,340.7	1.0	10,800.0	10,800.0	-	21,600.0	23,940.7	2,340.7
15	Монголиан транс ложистик ХХК	-	-	-					1.0	5,400.0	5,400.0	-	5,400.0	5,400.0	-
16	Шинэстэй ХХК-Ерөө сум	3,024.0	-	(3,024.0)									3,024.0	-	(3,024.0)
17	Төмөргэйн уурхай-Хүдэр сум	3,024.0	-	(3,024.0)									3,024.0	-	(3,024.0)
18	"ДСЦТШС" ХХК-Сэлэнгэ	14,400.0	-	(14,400.0)									14,400.0	-	(14,400.0)
19	"ДСЦТШС" ХХК-Мандал	-	-	-	1.0	7,200.0		(7,200.0)					7,200.0	-	(7,200.0)
20	Хайрхан буянт ХХК-Түнхэл	3,024.0	-	(3,024.0)									3,024.0	-	(3,024.0)
21	Техноперспектив ХХК-Түшиг	-	-	-	1.0	7,200.0		(7,200.0)					7,200.0	-	(7,200.0)
	Нийт дүн	222,631.2	86,345.2	(136,286.0)	21.0	136,656.0	161,912.7	25,256.7	5.0	33,264.0	22,212.0	(11,052.0)	392,551.2	270,469.9	(122,081.3)

Эх сурвалж: ХХҮГ-ын баримт

2.3.5 ХБИ ажиллуулаагүйн орлогыг дутуу төвлөрүүлж байгаа нь аймгийн ХХҮГ-ын албан хаагчид нь албан ёсны орлого төвлөрүүлэх, хяналт шалгалт хийх улсын байцаагчийн эрхгүй, ААНБ-д албан бичиг, нэхэмжлэх өгөхөөс бусдаар арга хэмжээ авах боломжгүй байдгаас тодорхой хэмжээгээр шалтгаалж байна.

2.3.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-23.1.10-д ХЭДС-ийн зарцуулалтын зориулалтыг тусгаж өгсөн байна.

2.3.7 ХЭДС-ийн зардалд 2016-2021 онуудад нийт 5,641,534.4 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 4,423,582.5 мянган төгрөг зарцуулж, төлөвлөгөөг 21.6 хувиар хэмнэсэн байна. */Дэлгэрэнгүй хавсралт 1-д харуулав./*

Хүснэгт 10. ХЭДС-ийн зардлын 2016-2021 оны төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих	57,104.6	39,503.3	17,601.3
2	Ажилд зуучлах үйлчилгээ	47,136.7	22,764.9	24,371.8
3	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах	213,249.0	157,373.5	55,875.5
4	Ажлын байрыг дэмжих	2,375,171.1	1,981,890.1	393,281.0
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	480,499.0	292,920.5	187,578.5
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	574,977.8	398,418.3	176,559.5
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,318,075.0	1,129,197.1	188,877.9
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	225,980.0	213,917.0	12,063.0
9	Хүүхэд хамгаалагч төсөл	11,760.0	5,376.0	6,384.0
10	Бусад зардал	337,581.2	182,221.8	155,359.4
	Зардлын нийт дүн	5,641,534.4	4,423,582.5	1,217,951.9

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.3.8 Сэлэнгэ аймгийн ХХҮГ нь ХЭДС-ийн батлагдсан төсвийг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр зориулалтын дагуу зарцуулсан боловч ажил олгогчийн урамшууллыг шалгуур хангаагүй дараах аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Үүнд:

- Баянгол сумын Гэгээн цолмон ХХК нь 2017 ажил олгогчид олгох урамшуулалд хамрагдах гэрээг аймгийн ХХҮГ-тай байгуулж 2018 онд шалгуур хангасан үндэслэлээр ажил олгогчийн урамшуулалд 2,880.0 мянган төгрөг олгосон байна. Гэвч тус компанийн шинээр бий болгосон байнгын ажлын байранд бүртгэлтэй иргэн нь 2018 оны 2-5 дугаар сарыг дуустал хугацаанд Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Лоудстоуне могул ХХК-д ажилласан байна.
- Цагааннуур сумын Бүтээлийн нуруу ХХК нь 2019 онд ажил олгогчид олгох урамшуулалд хамрагдах гэрээг аймгийн ХХҮГ-тай байгуулж 2020 онд шалгуур хангасан үндэслэлээр ажил олгогчийн урамшуулалд 4,640.0 мянган төгрөг олгосон байна. Гэвч тус компанийн шинээр бий болгосон байнгын ажлын байранд бүртгэлтэй иргэн нь 2020 оны 3 дугаар сараас хойш Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Амар екоммерс ХХК ажилласан байна

2.3.9 2016-2021 онуудад 2,853,725.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 840 иргэнд олгосон бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 29 иргэний 53,194.0 мянган төгрөгийн эргэн төлөлт хугацаа хэтэрч, үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 11. Санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтрэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Дэмжлэгт хамрагдсан иргэний тоо	Эргэн төлөгдөх дэмжлэг	Үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн дүн
2015 он	142	185,500.0	389.4	389.4
2016 он	45	98,830.0	-	
2017 он	182	601,550.0	20,392.0	21,959.0
2018 он	146	523,245.0	25,008.6	25,507.1
2019 он	149	761,600.0	279,996.9	5,338.5
2020 он	93	368,000.0	170,736.3	-
2021 он	83	315,000.0	255,965.5	-
Дүн	840	2,853,725.0	752,488.7	53,194.0

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын санхүүгийн тайлан

2.3.10 Хүснэгтээс харахад хугацаа хэтэрсэн эргэн төлөлт нь 2015-2019 онд олгосон 2,170.725.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 2.4 хувийг эзэлж байна.

2.3.11 Санхүүгийн дэмжлэгийг хугацаа хэтрүүлсэн 29 иргэнээс 4 иргэнийг шүүхэд, 15 иргэнийг ШШГГ-т шилжүүлж, 10 иргэнд мэдэгдэх хуудас өгч, барагдуулах арга хэмжээ авсан байна.

2.4 Мэргэжлийн боловсролыг дэмжих сан болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжсэн үү?

2016-2021 онуудад мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад олгосон санхүүжилтийн үр дүнд нийт 2697 мэргэжилтэй ажилчид бэлтгэгдсэн байна.

2.4.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь чиг үүргээсээ хамааран мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын болон мэргэжлийн сургалтын гэсэн ангилалтай байна. 12.3-т “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.” 12.5-д “Техникийн боловсролын сургалтын байгууллагын хэв шинж нь политехник коллеж байна.” гэж заасан байна.

2.4.2 Сэлэнгэ аймагт мэргэжлийн боловсрол олгох Сэлэнгэ аймгийн МСҮТ, Шаамар сумын МСҮТ, техникийн боловсрол олгох Зүүнхараа Политехникийн коллеж үйл ажиллагаагаа явуулж байна.

2.4.3 Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараах байдлаар хуваарилан зарцуулна. 23.1.1.төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн

дотуур байрны нийт зардал, 23.1.2.өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг” гэж заасан байна.

2.4.4 Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас 2016, 2020-2021 онуудад оюутан суралцагчдад олгох тэтгэлгийн санхүүжилтийг олгосон бөгөөд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагуудад урсгал үйл ажиллагааны санхүүжилт олгогдоогүй байна.

2.4.5 Улсын төсвөөс Сэлэнгэ аймгийн болон Шаамар сумын МСҮТ-ийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 2016-2021 онуудад нийт 11,458,029.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 10,927,656.3 мянган төгрөгийг зарцуулсан бол Зүүнхараа Политехникийн коллежид 6,679,526.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 6,531,568.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.4.6 Тайлант онуудад Сэлэнгэ аймгийн МСҮТ-ийг 8 мэргэжлээр 735 суралцагч төгсөж, нийт төгсөгчдийн 73.1 хувь нь буюу 537 суралцагч ажлын байраар хангагдсан гэж тайлагнасан бол Шаамар сумын МСҮТ-ийг мөн 8 мэргэжлээр 1004 суралцагч төгсөж, 437 буюу 43.5 хувь нь ажлын байраар хангагдсан гэж тайлагнагдсан байна.

2.4.7 Зүүнхараа Политехникийн коллежийг 2016-2021 онд 12-14 мэргэжлээр 958 суралцагч төгсөж, нийт төгсөгчдийн 84.7 хувь нь буюу 811 суралцагч ажлын байраар хангагдсан гэж тайлагнасан байна.

2.4.8 Өөрөөр хэлбэл мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудад олгосон санхүүжилтийн үр дүнд 30 орчим мэргэжлээр / давхардсан тоогоор / нийт 2697 мэргэжилтэй ажилчид бэлтгэгдсэн байна.

2.5 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна уу

Цар тахлын үед хэрэгжсэн хөтөлбөрүүдийн үр дүнд шинээр нэмэгдсэн ажлын байрны 60.3 хувийг түр ажлын байр эзэлж байна.

2.5.1 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 1 дүгээрийн тогтоолын 2 дугаар хавсралтаар “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг баталсан байна.

2.5.2 Тус хөтөлбөрийн зорилго нь Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

2.5.3 Тус хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн дараах 5 хөтөлбөр, арга хэмжээнд 543,990.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 510,791.3 сая төгрөг зарцуулагдаж, 123 байнгын, 449 түр ажлын байр бий болсон байна.

Хүснэгт 12. Хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2021 он				Ажлын байр	
		Батлагдсан төсөв	гүйцэтгэл	Зөрүү	Хамрагд-сан хүний тоо	байнгын	түр
1	Ажлын байрыг дэмжих	276,880.0	260,437.0	(16,443.0)	478	58	449
2	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	18,350.0	18,000.0	(350.0)	16	1	
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	122,480.0	108,360.6	(14,119.4)	83	20	
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	90,040.0	87,753.7	(2,286.3)	147	35	
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	36,240.0	36,240.0	-	21	9	
	Нийт дүн	543,990.0	510,791.3	(33,198.7)	745	123	449

Эх сурвалж: ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.5.4 Нийт санхүүжилтийн 51.0 хувийг ажлын байрыг дэмжих, 21.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, 17.2 хувийг малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тус тус зарцуулсан хэдий ч хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр дүнд дэмжигдсэн нийт ажлын байрны 60.3 хувийг түр ажлын байр эзэлж байгаа нь тогтвортой, үр нөлөө бүхий арга хэмжээ болж чадаагүй болохыг харуулж байна.

Хүснэгт №13. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтүүд

Он	Үзүүлэлт	ХБИ дэмжих	ЗХЭД, гарааны бизнесийг дэмжих	Малчдын хөдөлмөр эрхлэлт	Ажлын байрыг дэмжих	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	Нийт дүн
2019	Хүний тоо	13	18	52	57		140
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	52,000.0	180,000.0	242,600.0	262,000.0		736,600.0
	Бий болсон байнгын ажлын байр	13	18	104	107		242
2020	Хүний тоо	15		30	40	8	93
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	63,000.0		141,000.0	171,500.0	24,000.0	399,500.0
	Бий болсон байнгын ажлын байр	27		60	97	9	193
2021	Хүний тоо	20	1	18	36	9	84
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	85,600.0	10,000.0	84,000.0	162,000.0	27,000.0	368,600.0
	Бий болсон байнгын ажлын байр	20	1	35	58	9	123

Эх сурвалж: ХХҮГ-ын тайлан, мэдээ

2.5.5 Хүснэгтээс харахад цар тахлын үед буюу 2020, 2021 оныг 2019 онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилт 45.8-50.0

хувиар, байнгын ажлын байр 20.2-49.2 хувиар буурсан буюу цар тахал нь хөдөлмөр эрхлэлтийн салбарт сөргөөр нөлөөлсөн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын бичиг баримттай уялдуулсан аймгийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.
- Аудитад хамрагдсан 2016-2021 онуудад ХЭДС-д аймгийн төсвөөс 269,094.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх нөөц боломжийг төлөвлөөгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь төрийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.
- Түр ажлын байр нь ажил хөдөлмөр эрхэлдэг хүний тоог хий өсгөж, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг бууруулж байна.
- Нийтлэг үйлчилгээний төрөл нь зорилтод бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх хүсэл санаачилга, мэдлэгийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй байх зэрэг давуу талтай байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд зорилтод бүлэгт олгож буй бага хэмжээний санхүүгийн дэмжлэг нь ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэхээсээ илүү халамжийн шинж чанарыг агуулж байна.
- 2016-2021 онуудад ХЭДС-д 391,176.2 мянган төгрөг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.
- 2016-2021 онуудад мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад олгосон санхүүжилтийн үр дүнд нийт 2697 мэргэжилтэй ажилчид бэлтгэгдсэн байна.
- Цар тахлын үед хэрэгжсэн хөтөлбөрүүдийн үр дүнд шинээр нэмэгдсэн ажлын байрны 60.3 хувийг түр ажлын байр эзэлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Б. Нарантуяа-д:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1-т заасны дагуу тухайн жилийн аймгийн төсвийн орлогын 0.3 -аас багагүй хувийг ХЭДС-д төвлөрүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.2 -т заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн тайлан, мэдээллийг сонсох, хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

Аймгийн Засаг дарга Н. Лхагвадорж-д:

- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн зөвлөл”-ийг холбогдох журмын хүрээнд зохион байгуулах, удирдлагаар хангах.
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн зөвлөл”-ийн дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшинг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлэх.
- Аймаг, орон нутагт хэрэгжүүлсэн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр, төслийн үр дүн, нөлөөлөлд жил бүр үнэлэлт дүгнэлт хийж байх.

Аймгийн ХХҮГ-ын дарга Л. Зоригтбаатар-т:

- ХЭДС-ийн төсвийн төслийг өмнөх жилүүдийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн бодитоор боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.
- ХЭДС-ийн хөрөнгийг холбогдох эх үүсвэрээс бүрэн бүрдүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэх.
- Ажил олгогчийн урамшууллыг шалгуур хангаагүй аж ахуйн нэгжүүдэд олгосон зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах.
- ХЭДС-аас олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийг бүрэн төлүүлэх арга хэмжээ авах.

- ХЭДС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, зарцуулалтын үр дүнг үнэлэн, олон нийтэд ил тод мэдээлж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

Т.ОДСҮРЭН





**СЭЛЭНГЭ АЙМАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум,
Утас: 7036-2137, Факс: 7036-3045

2022.05.03 № 01/250

танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд нэмж, хасах санал байхгүй болно.

ДАРГА

Л.ЗОРИГТБААТАР



Сэлэнгэ аймгийн ХЭДС-ийн 2016-2021 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2016 он			2017 он			2018 он			2019 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	5,280.6	5,280.6	-	9,450.0	5,955.7	3,494.3	16,800.0	8,439.9	8,360.1	18,000.0	13,490.8	4,509.2
2	Ажилд зуучлах үйлчилгээ	2,789.6	2,789.6	-	11,080.0	2,342.8	8,737.2	12,140.0	5,147.7	6,992.3	12,600.0	5,381.0	7,219.0
3	Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	21,104.0	21,104.0	-	79,685.0	46,488.0	33,197.0	42,460.0	35,337.0	7,123.0	42,460.0	30,626.0	11,834.0
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	224,151.5	224,151.5	-	571,530.0	431,162.4	140,367.6	504,953.2	329,527.8	175,425.4	517,280.0	462,015.0	55,265.0
	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг	121,780.0	121,780.0	-	240,000.0	233,150.0	6,850.0	270,000.0	169,500.0	100,500.0	275,000.0	262,000.0	13,000.0
	Бүтэц зохион байгуулалтаар хүнсний ногоо тариалах	61,000.0	61,000.0	-	66,000.0	66,000.0	-	29,500.0	29,500.0	-	32,500.0	32,500.0	-
	Зохион байгуулалттай ажлын байр бий болгох зорилгот төслийн санхүүжилт							36,871.2	18,298.4	18,572.8	60,000.0	44,500.8	15,499.2
	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ-Ажил олгогчийн урамшуулал	2,304.0	2,304.0	-	46,080.0	-	46,080.0	34,560.0	2,880.0	31,680.0	13,840.0	13,760.0	80.0
	Нийтийг хамарсан ажил	39,067.5	39,067.5	-	189,300.0	127,677.4	61,622.6	106,400.0	105,900.0	500.0	112,000.0	106,404.2	5,595.8
	Бусад				30,150.0	4,335.0	25,815.0	27,622.0	3,449.4	24,172.6	23,940.0	2,650.0	21,090.0
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	18,059.0	18,059.0	-	110,690.0	19,695.0	90,995.0	119,460.0	44,816.5	74,643.5	211,540.0	191,650.0	19,890.0
	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг	18,000.0	18,000.0	-	72,000.0	18,000.0	54,000.0	92,000.0	40,785.0	51,215.0	180,000.0	180,000.0	-
	Аж ахуй эрхлэлтийн сургалт	59.0	59.0	-	3,810.0	1,695.0	2,115.0	3,060.0	1,530.0	1,530.0	13,300.0	11,650.0	1,650.0
	Бусад				34,880.0		34,880.0	24,400.0	2,501.5	21,898.5	18,240.0	18,240.0	-
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	38,227.0	38,227.0	-	139,630.0	58,568.9	81,041.1	96,860.0	44,619.9	52,241.0	92,540.0	65,142.0	27,398.0
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг	31,000.0	31,000.0	-	63,000.0	49,000.0	14,000.0	60,000.0	28,100.0	31,900.0	60,000.0	52,000.0	8,000.0
	ХБ-ийг ажил авсан ажил олгогчийг дэмжих арга хэмжээ-Ажил олгогчийн урамшуулал	2,304.0	2,304.0	-	8,640.0	-	8,640.0	14,400.0	8,640.0	5,760.0	9,600.0	5,760.0	3,840.0
	Санхүүгийн дэмжлэг-ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	2,760.0	2,760.0	-	45,000.0	-	45,000.0	2,400.0	512.0	1,888.0	2,940.0	7,382.0	15,568.0
	Аж ахуй эрхлэлтийн сургалт болон бусад	2,163.0	2,163.0	-	22,990.0	9,988.9	13,401.1	20,060.0	7,367.0	12,693.0	22,940.0	7,382.0	15,568.0
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	197,660.0	197,660.0	-	302,125.0	178,406.3	123,718.7	306,000.0	274,800.1	31,199.9	281,250.0	249,877.0	31,673.0
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг /4.0-5.0/ сая	197,660.0	197,660.0	-	285,000.0	173,900.0	111,100.0	300,000.0	288,860.0	31,140.0	260,000.0	242,600.0	17,400.0
	ММА эрхлэх сургалт, туршлага солилцох үйлгэлт				17,125.0	4,506.3	12,618.7	6,000.0	5,940.1	59.9	21,250.0	6,977.0	14,273.0
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	8,400.0	8,400.0	-	80,900.0	80,900.0	-	31,240.0	29,745.0	1,495.0	42,960.0	32,392.0	10,568.0
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх санхүүгийн дэмжлэг -3.0 сая				37,500.0	37,500.0	-	15,000.0	15,000.0	-	27,000.0	25,000.0	2,000.0
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	8,400.0	8,400.0	-	43,400.0	43,400.0	-	16,240.0	14,745.0	1,495.0	15,960.0	7,392.0	8,568.0
9	Хүүхэд хамгаалагч төсөл	26,856.4	26,856.4	-	65,750.0	32,805.3	33,144.7	51,016.0	18,978.8	32,036.2	79,418.0	59,418.0	20,269.0
10	Сургалт болон бусад арга хэмжээний зардал	542,528.1	542,528.1	-	1,370,800.0	856,144.4	514,655.6	1,180,929.2	791,412.8	389,516.4	1,302,752.0	1,113,986.8	188,765.2
	Зардлын нийт дүн												

Сэлэнгэ аймгийн ХЭДС-ийн 2016-2021 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа

Хавсралт 1

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2020 он			2021 он			НИЙТ ДҮН		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ажил нэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	25.0	26.0	27.0	29.0	30.0	31.0	32.0	33.0	34.0
2	Ажилд зуулах үйлчилгээ	2,174.0	2,174.0	-	5,400.0	4,162.3	1,237.7	57,104.6	39,503.3	17,601.3
3	Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	3,507.1	3,507.1	-	5,040.0	3,596.7	1,443.3	47,136.7	22,764.9	24,371.8
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	13,786.0	13,786.0	-	13,774.0	10,032.5	3,741.5	213,249.0	157,373.5	55,875.5
	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг	280,376.4	274,596.4	5,780.0	276,880.0	260,437.0	16,443.0	2,375,171.1	1,981,890.1	393,281.0
	Бүтэйн зохион байгуулалтаар хүнсний ногоо тариалах	171,500.0	171,500.0	-	175,000.0	162,000.0	13,000.0	1,253,280.0	1,119,930.0	133,350.0
	Зохион байгуулалттай ажлын байр бий болгох зорилгот төслийн санхүүжилт	32,495.0	32,495.0	-	-	-	-	221,495.0	221,495.0	-
	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ-Ажил олгогчийн урамшуулал	28,166.4	28,166.4	-	-	-	-	125,037.6	90,965.6	34,072.0
	Нийтийг хамарсан ажил	14,320.0	14,120.0	200.0	10,080.0	10,080.0	-	121,184.0	43,144.0	78,040.0
	Бусад	26,695.0	26,695.0	-	84,000.0	84,000.0	-	557,462.5	489,744.1	67,718.4
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	7,200.0	1,820.0	5,380.0	7,800.0	4,357.0	3,443.0	96,712.0	16,611.4	80,100.6
	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг	2,400.0	700.0	1,700.0	18,350.0	18,000.0	350.0	480,499.0	292,920.5	187,578.5
	Аж ахуй эрхлэлтийн сургалт	-	-	-	10,000.0	10,000.0	-	372,000.0	266,785.0	105,215.0
	Бусад	2,400.0	700.0	1,700.0	8,000.0	8,000.0	-	28,229.0	22,934.0	5,295.0
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	85,240.8	83,480.8	1,760.0	122,480.0	108,360.6	14,119.4	574,977.8	398,418.3	176,559.5
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг	63,000.0	63,000.0	-	84,000.0	84,000.0	-	361,000.0	307,100.0	53,900.0
	ХЕМ-ийг ажилд авсан ажил олгогчийг дэмжих арга хэмжээ-Ажил олгогчийн урамшуулал	12,020.0	12,020.0	-	10,080.0	10,080.0	-	57,044.0	38,804.0	18,240.0
	Санхүүгийн дэмжлэг-ажлын байрыг түрээсийн хөнгөлөлт	4,188.8	2,428.8	1,760.0	14,700.0	11,042.6	3,657.4	69,048.8	16,743.4	52,305.4
	Аж ахуй эрхлэлтийн сургалт болон бусад	6,032.0	6,032.0	-	13,700.0	3,238.0	10,462.0	87,885.0	35,770.9	52,114.1
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	141,000.0	141,000.0	-	90,040.0	87,753.7	2,286.3	1,318,075.0	1,129,197.1	188,877.9
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг /4.0-5.0/ сая	141,000.0	141,000.0	-	85,000.0	84,000.0	1,000.0	1,288,680.0	1,108,020.0	180,660.0
	МАН эрхлэлт, туршлага солилцох үзлэлт	-	-	-	5,040.0	3,753.7	1,286.3	49,415.0	21,177.1	28,237.9
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	26,240.0	26,240.0	-	36,240.0	36,240.0	-	225,980.0	213,917.0	12,063.0
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх санхүүгийн дэмжлэг - 3.0 сая	24,000.0	24,000.0	-	27,000.0	27,000.0	-	130,500.0	128,500.0	2,000.0
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	2,240.0	2,240.0	-	9,240.0	9,240.0	-	95,480.0	85,417.0	10,063.0
9	Хүүхэд амгаалагч төсөл	4,704.0	812.0	3,892.0	2,352.0	2,352.0	-	11,760.0	5,376.0	6,384.0
10	Сургалт болон бусад арга хэмжээний зардал	40,027.6	16,225.2	23,802.4	74,513.2	28,408.1	46,105.1	337,561.2	182,221.8	155,339.4
	Зардлын нийт дүн	599,455.9	562,521.5	36,934.4	645,069.2	556,985.9	88,080.3	5,641,534.4	4,423,582.5	1,217,951.9